



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 8/7

Сангийндалай

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, “Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр “Эрүүл мэндийн төвд бага үнэт түргэн элэгдэх материал нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Өнөрбилэг (Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга: Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

Гишүүдэд: Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

Ж.Хишигсүрэн (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

С.Нямаа (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивд хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ

482302141